

# НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 3 сарын 19-ний өдөр

Дугаар05

“ГТХЗНТ” УТҮГ

## Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмыг хэрэгжүүлэх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хариуцсан нэгж, ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлэх, ажилд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

## Танилцуулга:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх 10, хүний нөөцийн талаарх 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх 27, чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар 2, өөрийн эрхлэх асуудлын хүрээний 22, нийт 67 мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан.

Мэдээлэл хариуцагч хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан хүргэхээр хуульчилсан байна.

Нээлттэй мэдээлэх 67 мэдээллийг агуулга, сэдэв тус бүрээр нарийвчлан ангилахад 116 мэдээлэл болж байгаа бөгөөд үүнээс Хөдөлгөөн зохицуулалтын төвд хамаарахгүй 66 мэдээллийг хасаж, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтын 5.21, 5.22-т заасан мэдээллийг нэмж байгууллагын вэбсайт ([www.rtcc.mrtd.gov.mn](http://www.rtcc.mrtd.gov.mn)), мэдээллийн самбар, фэйсбүүк пэйж, шилэн дансны цахим хуудсыг (<https://shilendans.gov.mn>) тус тус ашиглан нийт 52 мэдээллийг хамруулав.

## Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ:

№	Нээлттэй мэдээлэл	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хэрэгжилтийн хувь
		Мэдээллийн хүртээмжтэй байдал	Хугацаандаа нийтлэгдсэн байдал	Мэдээллийн бүрэн бүтэн байдал	Эх сурвалжийн тодорхой байдал	
<b>Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын</b>						
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	20	10	15	30	63%

1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	18.3	30	15	30	78%
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	10	10	15	30	55%
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	15	30	30	30	88%
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	15	30	30	30	88%
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	15	10	15	30	59%
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	20	30	30	30	92%
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	15	30	30	30	88%
Дундаж оноо, хувь		128.3	180	180	240	76.4%
Тайлбар: 1.4, 1.5-д заасан мэдээлэл хамааралгүй тул хасав.						
<b>Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал</b>						
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	15	10	15	30	59%
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	15	30	30	30	88%
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	15	30	30	30	88%
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	15	30	30	30	88%
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	20	10	15	30	63%
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	15	30	30	30	88%
Дундаж оноо, хувь		95	140	150	180	79.0%
<b>Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны</b>						
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл					100%
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан					100%
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт					ХБ
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар					100%

3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг					100%
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт					100%
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл					ХБ
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан					100%
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт					ХБ
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл					30%
Дундаж оноо, хувь						90.0%
Тайлбар1: 3.4, 3.8, 3.13-3.28-д заасан мэдээлэл хамааралгүй тул хасав.						
Тайлбар2: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.15 дахь хэсэгт "Энэ хуулийн 8.4-т заасан мэдээллийг нээлттэй, ил тод байлгахтай холбогдсон нарийвчилсан харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулна." гэж заасан.						
<b>Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн</b>						
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	20	10	30	30	75%
Дундаж оноо, хувь		20	10	30	30	75.0%
Тайлбар: 4.2-т заасан мэдээлэл хамааралгүй тул хасав.						
<b>Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал</b>						
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	15	10	15	10	42%

5.21	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	25	10	15	30	67%
5.22	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	5	30	30	30	80%
Дундаж оноо, хувь		45	50	60	70	63%
<b>Үнэлгээний ерөнхий оноо, хувь</b>		<b>288.3</b>	<b>380</b>	<b>420</b>	<b>520</b>	<b>79.2%</b>
Тайлбар: 5.1, 5.2, 5.3, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.16, 5.17, 5.18, 5.19, 5.20, 5.23, 5.24, 5.25-д заасан мэдээлэл хамааралгүй тул хасав.						

### Дүгнэлт:

Хөдөлгөөн зохицуулалтын төвийн вэбсайт, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэлд нийт 858 мэдээлэл нийтлэгдсэн байна.

Нийтлэгдсэн мэдээллийг огноогоор ангилахад 2018 онд 4.4 хувийг, 2019 онд 5.02 хувийг, 2020 онд 6.9 хувийг, 2021 онд 13.8 хувийг, 2022 онд 16.7 хувийг, 2023 онд 35.1 хувийг, 2024 онд 2.0 хувийг нийтэлсэн байх бөгөөд оруулсан хугацаа тодорхойгүй мэдээлэл 16.2 хувийг эзэлж байна.

2024 онд нийтэлсэн мэдээлэл 2.0 хувийг эзэлж байгаа нь байгууллагын вэбсайт 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс ажиллаагүйтэй холбоотой.

Холбогдох хууль тогтоомжид заасан, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилготой мэдээллийн ил тод байдлын биелэлт 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 79.2 хувийн хэрэгжилттэй байна.

Мэдээллийн 42.3 хувь нь нэг удаагийн шинж чанартай, 57.7 хувийг шинэчилж, баяжуулж нийтлэх мэдээлэл эзэлж байна.

### Санал зөвлөмж:

1. Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын **"4.2.Мэдээлэл хариуцагч нь цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын зөрчил, саатал гарсан тохиолдолд шалтгааныг даруй тодруулж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана."** гэж заасны дагуу төвийн вэбсайтыг яаралтай ажиллуулах;

2. Мөн журмын **"1.2.Нийтийн мэдээлэл хариуцагч (цаашид "мэдээлэл хариуцагч" гэх) нь хууль болон энэ журамд нийцүүлэн нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих талаар дотоод журам батлан мөрдүүлж болно."** гэж заасны дагуу 2 жилийн өмнө боловсруулсан "Цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээлэл, контент байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам"-ыг батлуулж мөрдөх, журам шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд №3-т дурдсан зөвлөмжийг заавал хэрэгжүүлэх;

3. Мөн журмын **“2.3.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг байршуулж нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцах ажилтныг (цаашид “эрх бүхий ажилтан” гэх) томилон ажиллуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.”**, **“5.2.Мэдээлэл хариуцагч нь нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэхтэй холбогдох үүргийг эрх бүхий ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгана.”**, Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандартын **“4.1.16 Вэбсайт нь бэлтгэгч, нийтлэгчтэй байна. Бэлтгэгч нь вэбсайтын мэдээллийг бэлтгэнэ. Нийтлэгч нь мэдээллийг хянаж вэбсайтад нийтэлнэ.”**, **“4.1.17 Бэлтгэгч, нийтлэгч нь нэг хүн байж болохгүй.”** гэж заасан.

Практик дээр хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн нар (өмнө нь хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн) бэлтгэгч, нийтлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.

Иймд ил тод, нээлттэй байлгах мэдээллийн ангилал, төрлийн дагуу нийт ажилтны албан тушаалын тодорхойлолтод **“мэдээлэл бэлтгэх болон мэдээллийн үнэн зөв байдлыг хангах чиг үүргийг”**, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтний АТТ-д нээлттэй мэдээллийг байршуулж нийтлэх, шинэчлэх буюу **“мэдээлэл нийтлэгчийн чиг үүргийг”**, цахим хөтөлбөр хариуцсан мэргэжилтний АТТ-д **цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцах (администратор) чиг үүргийг** тус тус тусгаж батлуулах;

4. Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага MNS 6285:2017 стандартын **“4.1.3 Вэбсайтын агуулга нь нийтлэгдсэн огноотой байна.”**, **4.1.18 Вэбсайтын мэдээллийг нийтлэхээс өмнө заавал хянана.”** гэж заасны дагуу нээлттэй мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд, бусад мэдээллийг тухай бүр шинэчилж (өмнөх мэдээллийг устгахгүй архивлах) тогтмол хяналт тавьж ажиллах;

5. Хэрэглэгчдийн үздэг түгээмэл мэдээллийг вэбсайтын нүүр хуудсанд хэвлэх;

6. Удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр төвийн вэбсайт дахь дараах мэдээллийг засварлах. Үүнд:

а) “Бидний тухай” бүлгийн “Төвийн бүтэц” цэсний Захиргаа, санхүүгийн хэлтэс “Гадаад, дотоод хамтын ажиллагаа”

б) “Бидний тухай” бүлгийн “Төвийн бүтэц” цэсний Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс “Чингэлэгийн”, “Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олголт”, “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт”, “Статистик, тоон мэдээлэл бүрдүүлэлт, дүн шинжилгээ “

в) “Бидний тухай” бүлгийн “Хэлтсүүд” цэсний Захиргаа, санхүүгийн хэлтэс, Зорилго хэсэг дэх “Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх”, Үйл ажиллагааны чиглэл хэсэг дэх “Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх”, “Боловсон хүчний”, “Төмөр замын тээврийн салбарын эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх асуудлаар санал дэвшүүлж шийдвэрлүүлэх”, ажилтнуудын жагсаалтын №4, 5.

г) “Бидний тухай” бүлгийн “Хэлтсүүд” цэсний Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс хэсгийн ажилтнуудын жагсаалтын №2, 3, 6, 7, 9.

д) “Бидний тухай” бүлгийн “Хэлтсүүд” цэсний Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэл хэсэг дэх “Төмөр замын

тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах”, “Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлж хөтлөх, төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах”, “Гэрчилгээжүүлэлтийн цахим системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, зүгшрүүлэх ажлыг зохион байгуулах, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах”, “Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, ашиглах, дүн шинжилгээ хийх”, “Үндэсний статистикийн хороо, Зам, тээврийн хөгжлийн яамыг салбарын статистик мэдээллээр хангах”, “чингэлэгт”, ажилтнуудын жагсаалтын №3, 4, 6, 7.

е) “Хууль эрх зүй” бүлгийн “Монгол Улсын хууль” цэсний 24. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль – файл хавсаргах

ё) “Хууль эрх зүй” бүлгийн “Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал” цэсний №2, 4 - төлөвлөгөө байна, №3 - албан бичиг байна

ж) “Хууль эрх зүй” бүлгийн “Дүрэм, журам” цэсний №1, 2 – Засгийн газрын тогтоол цэс рүү, №3 – Хүний нөөцийн стратеги цэс рүү оруулах

з) “Хууль эрх зүй” бүлгийн “Дүрэм, журам” цэсний №4, 5, 6 – төлөвлөгөө байна

и) “Хууль эрх зүй” бүлгийн “Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал” цэсэнд төвийн чиг үүрэгтэй холбоотой ЗТХ-ийн сайдын 2023 оны А/37, А328 дугаар тушаалаар баталсан “Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”, “Төмөр замын сүлжээнд суурь бүтэц хооронд тээвэрлэлтийг зохион байгуулах нэгдсэн технологийн түр горим”-ыг шинээр байршуулж мэдээлэх

й) “Ил тод байдал” бүлгийн “Хүний нөөцийн ил тод байдал” цэсний “Албан хаагчдын мэдээлэл” хэсэг дэх №10-ыг засах, №12-ыг нэмэх, №18, 19, 20-ыг засах

к) “Мэдээ, мэдээлэл” бүлгийн “Мэдээ” цэсний 4-р хуудсанд “Суурь бүтэц эзэмшигчдийн ачаа тээвэр, тээвэр логистикийн туршлага солилцох нь сэдэвт зөвлөгөөн зохион байгуулагдлаа”, “Суурь бүтэц эзэмшигчдийн ачаа тээвэр, тээвэр логистикийн туршлага солилцох нь сэдэвт зөвлөгөөн” гэсэн 2 мэдээлэл давхацсан

л) “Хөгжлийн сэргэлт” зам, тээврийн салбарын залуучуудын “зөвлөгөө” – засах

м) “Үйл ажиллагаа” бүлгийн “Хөдлөх бүрэлдэхүүн дугаарлалт” цэс дэх “Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”- хуучин журмыг шинэчлэх

7. Удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр төвийн вэбсайт дахь дараах мэдээллийг устгах. Үүнд:

а) “Хууль эрх зүй” бүлгийн “Монгол Улсын хууль” цэсний 5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай – хүчингүй болсон

б) “Хууль эрх зүй” бүлгийн “Монгол Улсын хууль” цэсний 2. Зөрчлийн тухай, 22. Зөрчлийн тухай – 2 удаа байршуулсан

в) “Хууль эрх зүй” бүлгийн “Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал” цэсний №11, 27 Эрх шилжүүлэх тухай тушаал – 2 удаа байршуулсан


г) "Хууль эрх зүй" бүлгийн "Дүрэм, журам" цэсний №9 – албан бичиг, №11 дэх журам – хүчингүй болсон

д) "Хууль эрх зүй" бүлгийн "Дүрэм, журам" цэсний №19, 24, 29, 30-д байршуулсан тушаалууд – хүчингүй болсон.


**ТАНИЛЦСАН:**

"ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН  
НЭГДСЭН ТӨВ" УТУГ-ЫН ЗАХИРАЛ  А.БУЯАННЭМЭХ

ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН  
АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Ц.ОЮУНБАТ

ТЭЭВРИЙН НЭГДСЭН УДИРДЛАГА,  
АВТОМАТЖУУЛАЛТ, СУДАЛГААНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.АЛИМАА

**БОЛОВСРУУЛСАН:**

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
МЭРГЭЖИЛТЭН  Э.ОСОРЖАМАА  
III/21.